

## ГАДААД ХУДАЛДАА ЭРХЛЭГЧДИЙН БИЗНЕС ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД

**Р.Шарбанди\*, Б.Даваасүрэн\*\***

**Хураангуй:** Гадаад худалдаа эрхлэх нь бизнес эрхлэгчийн мэдлэг, туршлага, ур чадвараас гадна төрийн бодлого, зохицуулалт, төрийн зарим байгууллагын үйл ажиллагаа, олон улсын болон төрийн бус байгууллагуудын дэмжлэг тусламж, гадаад худалдаа эрхлэгчдэд зориулсан бизнесийн үйлчилгээ, цаашилбал бизнесийн орчны ерөнхий төлөв байдал зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

Энэхүү судалгаагаар Монгол Улсад гадаад худалдаа эрхлэхэд тулгарч буй сорилт бэрхшээл, нөхцөл байдлыг гадаад худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээр үнэлүүлж, цаашид гадаад худалдаа эрхлэх илүү таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд анхаарч ажиллавал зохих бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлохыг зорьлоо.

Судалгаанд оролцогчид Монгол Улсад гадаад худалдаа эрхлэхэд *хүндрэлтэй* хэмээн дүгнэсэн бөгөөд гадаад худалдаанд оролцогч бүхий л талууд үйл ажиллагаагаа уялдуулах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай гэж үзжээ.

**Түлхүүр үгс:** Гадаад худалдаа, экспорт, импорт, зохицуулалт, дэмжлэг.

### STUDY ON THE CURRENT SITUATIONS AND SOME ISSUES IN BUSINESS CLIMATE FOR FOREIGN TRADERS

**Abstract:** Business environment for foreign trade depends on many factors, including government policies and regulations, government services, support from international and non-governmental organizations, business services to foreign trade entities, and the general state of the business environment. Also firm-level characteristics are important determinants of foreign trade success. The purpose of this study is to assess the current situation and challenges facing foreign trade in Mongolia and to propose policies and measures to be taken to create a more favorable environment for foreign trade.

Results indicate that, it is difficult to conduct foreign trade in Mongolia and it is necessary to facilitate foreign trade, coordinate the activities of all parties involved in foreign trade, and expand cooperation.

**Key words:** Foreign trade, export, import, regulation, support.

\* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail): sharbandi@num.edu.mn

\*\* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail): davaasurenb@num.edu.mn

## 1. ОРШИЛ

Бизнесийн орчинг цаг хугацааны тодорхой давтамжтайгаар судлан шинжилж, бизнес эрхлэх тааламжтай, тогтвортой орчинг бүрдүүлэх нь эдийн засаг, нийгмийн олон талын ач холбогдолтой юм. Бизнесийн орчинг илтгэх нэг чухал үзүүлэлт нь гадаад худалдаа эрхлэх боломж, нөхцөл тул энэхүү судалгааны хүрээнд гадаад худалдаа эрхлэхэд тулгарч буй сорилт бэрхшээл, нөхцөл байдлыг гадаад худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээр үнэлүүлж, улмаар гадаад худалдаа эрхлэх илүү таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд төр засаг, олон нийтийн байгууллага, бизнес эрхлэгчдийн зүгээс анхаарч ажиллавал зохих бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлохыг зорьлоо. Тус судалгааг “Монголын бизнесийн орчин 2020” судалгааны дэд сэдвийн хүрээнд хийсэн бөгөөд судалгааны үр дүнг 2017 онд хийгдсэн өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулж, ахиц дэвшил гарсан эсэхийг тодорхойллоо.

### Судлагдсан байдал

Гадаад худалдаа эрхлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар олон улсын байгууллагууд болон судлаачид дараах 2 чиглэлээр төвлөрч судалжээ.

*Нэгдүгээрт*, улс орнуудын экспортын өрсөлдөх чадвар, экспортын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, тэдгээрийн нөлөөллийг үнэлэх чиглэлээр олон тооны судалгааны ажлууд хийгдсэн байна. Тухайлбал, Millath and Thowseaf (2016) нар улс орны экспортод бизнесийн орчны ерөнхий төлөвөөс гадна компани, улс орон, глобал түвшний хүчин зүйл нөлөөлдөг гэж үзсэн. Тэд компанийн түвшний үзүүлэлтэд бүтэц зохион байгуулалт, удирдлагын ур чадвар, хүний нөөцийн чадавх, үйлдвэрлэлийн процессын өгөөж, тээвэрлэлтийн нөхцөл боломж зэргийг хамруулсан бол улс орны түвшний хүчин зүйлд нийгэм, технологи, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлс, глобал түвшинд олон улсын гэрээ хэлэлцээр, олон улсын байгууллагуудын үйл ажиллагаа болон байгаль цаг уурын нөхцөл байдал, байгалийн баялаг гэсэн үзүүлэлтүүдийг хамруулсан байна.

Babatunde (2012) экспортын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлсийг эрэлтийн талын буюу импортлогч улсын, нийлүүлэлтийн талын буюу экспортлогч улсын орчин нөхцөл хэмээн ангилж судалсан. Тэрээр улс орны экспортын гүйцэтгэлд улс орон, бүс нутаг, түүнчлэн бараа, бүтээгдэхүүний онцлогоос хамааран харилцан адилгүй хүчин зүйлс нөлөөлөх бөгөөд эрэлт талаасаа импортлогч улсын орлогын түвшин, худалдааны либералчлал чухал бол нийлүүлэлт талаас худалдааны бодлогын шинэчлэл, гадаад зах зээлд нэвтрэх боломж, байгаль цаг уурын онцлог, институцийн чанар, экспортын дэмжлэг, урамшуулал, түүнчлэн

бодлогын бус саад бэрхшээлүүд нөлөөлдөг гэж үзжээ.

Fugazza (2004) дэлхийн улс орнуудыг бүсчлэн ангилж, тэдний экспортод нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон. Судалгааны үр дүнгээс худалдааны саад бэрхшээл болон нийлүүлэлт талын хүчин зүйл экспортод хамгийн их саад болдог гэж дүгнэсэн. Мөн тээврийн дэд бүтэц, макро эдийн засгийн тогтвортой байдал, институцийн чанар чухал гэж үзжээ. Тус судалгаанд дотоодын тээврийг тээврийн дэд бүтэц болон зардлаар, макро эдийн засгийн орчинг валютын бодит ханшаар, институцийн чанарыг улс орнуудын эрсдэлийн индекс болон хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтээр, гадаад зах зээлд нэвтрэх боломжийг газар зүйн нөхцөл байдал, гадаад худалдааны бодлого, худалдааны түнш орнуудын зах зээлийн багтаамж зэрэг үзүүлэлтээр үнэлсэн байна.

Түүнчлэн, Yang and Millick (2013) нар макро эдийн засгийн хүчин зүйлс, Besedes and Blyde (2010) нар зах зээл хоорондын алслагдсан байдал болон зах зээл хоорондын ижил төстэй байдал, тээврийн зардал, эрэлтийн мэдрэмж, Commander and Svejnar (2009) нар бизнесийн орчны хязгаарлалт, өрсөлдөөн, компанийн эзэмшил, харьяалал, Calantone R.J et al. (2005) нар компанийн бизнесийн орлогын экспортоос хамаарах байдал, инновацийг нэвтрүүлэх чадвар, зах зээл хоорондын ижил төстэй байдал, Julian (2004) компанийн дотоод хүчин зүйлс, экспортын маркетингийн стратеги, экспортын зах зээл дэх өрсөлдөөн зэрэг нь экспортын чадвар, гүйцэтгэлд ямар нөлөөтэйг судалсан байна.

*Хоёрдугаарт*, олон улсын байгууллагууд: (а) улс орнуудын бизнесийн орчин, (б) гадаадын шууд хөрөнгө оруулалтын орчин, гадаадын компаниуд бизнес эрхлэх боломж, (в) тухайн улсын экспортын чадавх, экспортын гүйцэтгэлийг үнэлэх, харьцуулах судалгаа хийж байна. Эдгээрээс Дэлхийн банкны Бизнес эрхлэхүй (Doing Business) индексийг олон улсын байгууллагууд, шийдвэр гаргагч, судлаачдын дунд хамгийн түгээмэл ашигладаг. Гэхдээ Бизнес эрхлэхүй индекс нь нэгэн ижил аргачлалаар дэлхийн улс орнуудын бизнесийн орчны ерөнхий төлөв байдлыг тодорхойлж, хооронд нь харьцуулах, эрэмбэлэх, бизнесийн орчинд гарсан ахиц, өөрчлөлтийг харуулах давуу талтай ч тухайн улс орны онцлог, ялгаатай байдлыг илэрхийлдэггүй (Hoyland.B et al. 2012) сул талтай юм.

### **Судалгааны арга зүй, мэдээлэл боловсруулалт**

Бид асуулга боловсруулахдаа Дэлхийн Банкны Бизнес эрхлэхүй судалгааны үндсэн үзүүлэлтүүдийг суурь болгон ашигласан. Мөн экспорт хийхэд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийг тодорхойлсон дээрх судалгааны ажлуудын

үзүүлэлтүүдээс асуулгад тусгаж, өөрийн улсын онцлог, нөхцөл байдлыг харгалзан асуулгыг боловсрууллаа. Цаашид энэхүү судалгааны загвараар, тодорхой хугацааны давтамжтайгаар, тогтмол судалгаа хийж, үр дүн, ахиц дэвшлийг харьцуулахаар төлөвлөж байна.

Судалгаанд тоон судалгааны аргачлалыг ашиглан, харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг ашиглав. Аж ахуйн нэгжүүдийг энгийн түүврийн аргаар сонгон судалгаанд хамрууллаа. Үр дүнг үндэсний хэмжээнд болон аймаг, эдийн засгийн салбараар тархаав.

Судалгааны түүврийн хэмжээг тогтоохдоо 2020 оны 3 сарын байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжийн тоонд үндэслэн, Улаанбаатар хот ба аймгуудын төлөөлөх чадварыг чухалчилж тогтоов.

### **Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл**

Судалгаанд гадаад худалдаа эрхлэгч 1111 ААН (аж ахуйн нэгж)-ийг хамруулав. Тэдний 45.5% нь бичил, 26.2% нь жижиг, 10% нь дунд, 1.7% нь том аж ахуйн нэгж байв. Байршлаар авч үзвэл 46.3% нь Улаанбаатар хотод харьяалагдаж байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 14% буюу 158 нь экспорт хийдэг бөгөөд үүнээс 30 нь уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогч, 128 нь уул уурхайн бус бүтээгдэхүүн экспортолдог аж ахуйн нэгжүүд байв.

## **2. СУДАЛГААНЫ ҮР ДҮН**


Бид гадаад худалдаа эрхлэх нөхцөл байдлыг: *(а)* экспортыг дэмжих үйл ажиллагаа, *(б)* экспорт, импортын зөвшөөрөл олгох үйл явц, *(в)* гадаад худалдаа эрхлэгчдэд чиглэсэн бизнесийн үйлчилгээ, *(г)* дотоодын тээвэр, *(д)* хил, гаалийн үйлчилгээ, *(е)* гадаад улсын зохицуулалт, хил гаалийн үйлчилгээ, *(ё)* гадаад худалдаа эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл, *(ж)* эдийн засгийн хэлэлцээрүүдийн үр дүн гэсэн үзүүлэлтээр судаллаа.

### **2.1. Экспортыг дэмжих үйл ажиллагаа**

Хөгжиж буй орны экспортлогчдын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын зах зээлд гаргахад төр, олон улсын байгууллага, олон нийтийн байгууллагын дэмжлэг, тусалцаа нэн хэрэгцээтэй юм. Иймд экспортын чиглэлээр ажиллаж буй ахуйн нэгжүүдэд хандсан төрийн, олон улсын байгууллагын, төрийн бус байгууллагын дэмжлэг ямар байгааг үнэлүүлэв. Асуулгад бүтээгдэхүүн экспортолдог 158 аж ахуйн нэгж хариулж, экспортыг дэмжих үйл ажиллагааг

2.37 оноогоор<sup>3</sup> “*муу*” гэж үнэлжээ. Ялангуяа экспортыг дэмжихэд чиглэсэн төрийн байгууллагын үйл ажиллагаа, санаачлагыг хамгийн бага оноогоор дүгнэсэн байна (Зураг1).


Зураг 1. Экспортын дэмжлэгийн үнэлгээ<sup>4</sup>



Эх сурвалж: Монголын бизнесийн орчны судалгаа 2020

Экспортыг дэмжихэд аль байгууллага илүү идэвх, санаачлагатай оролцох шаардлагатайг тодруулахад (Зураг 2) судалгаанд оролцогчдын олонх нь төр засгийн дэмжлэг (40%) -ийг чухалчилжээ.

Зураг 2. Экспортыг дэмжихэд аль байгууллагын үүрэг, оролцоо чухал вэ?



Эх сурвалж: Монголын бизнесийн орчны судалгаа – 2020

## 2.2. Экспорт, импортын зөвшөөрөл олгох үйл явц

Экспорт, импортын зөвшөөрөл олгох үйл явцын үнэлгээгээр нэг талаас гадаад худалдаа эрхлэгчдэд тулгардаг хүндрэл, нөгөө талаас төрийн

<sup>3</sup> Үнэлгээний тайлбар: 1-маш муу, 2-муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн


<sup>4</sup> Үнэлгээний тайлбар: Баганад бичигдсэн тооны утга 1-маш муу, 2-муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн

байгууллагын үйлчилгээний чанар, хурдан шуурхай байдлыг үнэлэхийг зорьлоо.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн дийлэнх нь экспорт, импортын зөвшөөрөл авахад цаг хугацаа их зарцуулдаг (51.4%), зөвшөөрөл авахын тулд бүрдүүлэх бичиг баримтын тоо олон (50.9%), зөвшөөрөл авахад гарах зардал, төлбөр хураамжийн хэмжээ өндөр (48.3%) гэж хариулж, экспорт, импортын зөвшөөрөл олгох үйл явцыг хүндрэлтэй (зарцуулах хугацаа 2.39, шаардах бичиг баримт 2.42, төлбөр хураамжийн хэмжээ 2.47) хэмээн дүгнэжээ (Зураг 3). Ялангуяа экспорт, импортын зөвшөөрөл авахад хугацаа их зарцуулдаг гэсэн байна.

Иймд экспорт, импортын зөвшөөрөл олгох үйл явцыг хялбарчлах, цахимжуулах шаардлагатай байна.

Зураг 3. Экспорт, импортын зөвшөөрөл авах үйл явцын үнэлгээ<sup>5</sup>



Эх сурвалж: Монголын бизнесийн орчны судалгаа 2020

### 2.3. Гадаад худалдаа эрхлэгчдэд чиглэсэн бизнесийн үйлчилгээ

Гадаад худалдаа эрхлэгчдэд зориулсан бизнесийн үйлчилгээний чанар, хүртээмж нь гадаад худалдаа эрхлэх боломж, нөхцөлийг илэрхийлэх нэг чухал үзүүлэлт болох юм. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд бизнесийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дараах байдлаар үнэлсэн байна. Үүнд:


- Гадаад худалдааны санхүүжилт авах боломж - **муу (2.26)**
- Бизнесийн зөвлөгөө - **хангалтгүй (2.38)**
- Гадаад төлбөр тооцоо - **хангалтгүй (2.64)**
- Гадаад худалдааны даатгал - **хангалтгүй (2.54)**

<sup>5</sup> Үнэлгээний тайлбар: Багад бичигдсэн тооны утга 1-маш муу, 2-муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн

- Тээвэр зуучийн үйлчилгээ - дундаж (2.88)

Зураг 4-т судалгаанд оролцогчдын хариултын хувь, дундаж үнэлгээг дэлгэрэнгүй харууллаа.

Зураг 4. Гадаад худалдаа эрхлэгчдэд чиглэсэн үйлчилгээний үнэлгээ<sup>6</sup>



Эх сурвалж: Монголын бизнесийн орчны судалгаа 2020

Дээрх үр дүнгээс харахад гадаад худалдаа эрхлэгчдэд чиглэсэн бизнесийн үйлчилгээ хангалттай түвшинд хүрч хөгжиж чадаагүй нь гадаад худалдаа эрхлэхэд саад тотгор учруулж байна.


#### 2.4. Дотоодын тээвэр

Гадаад худалдаа эрхлэхэд дотоодын тээврийн хүртээмж, олдоц, зардал ямар нөлөө үзүүлж буйг тодорхойлох зорилгоор тээврийн зардал, зарцуулах хугацаа, тээврийн олдоц, хүрэлцээ гэсэн 3 дэд үзүүлэлтээр үнэллээ.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд экспорт, импорт хийхэд дотоодын тээврийн зардал өндөр (50.4%), тээвэрлэлтэд зарцуулах хугацаа их (41.5%), тээврийн олдоц, хүрэлцээ хангалтгүй (37.3%) байгаа нь саад, бэрхшээл учруулж байна гэж хариулжээ. Тодруулбал дотоодын тээврийн чанар, хүртээмж, үр ашигт байдал нь гадаад худалдааг хязгаарлах хүчин зүйл болж байна (Зураг 5).

<sup>6</sup> Үнэлгээний тайлбар: Багад бичигдсэн тооны утга 1-маш муу, 2-муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн

Зураг 5. Гадаад худалдаатай эрхлэхтэй холбоотой дотоодын тээврийн үнэлгээ<sup>7</sup>



Эх сурвалж: Монголын бизнесийн орчны судалгаа 2020

Дотоодын тээврийн нөхцөл байдлыг 2017 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад дотоод тээврийн зардал өндөр (маш их, их) гэж 56% нь хариулж байсан бол 2020 оны судалгаагаар 50% болж 6 пунктээр, дотоодын тээвэрт зарцуулах хугацаа их (маш, их) гэсэн хариулт 53%-аас 41% болж 12 пунктээр, тээврийн олдоц, хүрэлцээ хангалтгүй (маш хангалтгүй, хангалтгүй) гэсэн үнэлгээ 54%-аас 48% болж 6 пунктээр тус тус буурч, дотоодын тээвэрт ахиц гарсан гэж дүгнэсэн байна.

## 2.5. Хил, гаалийн үйлчилгээ

Хил гаалийн үйл ажиллагааг хил дээр зарцуулах хугацаа, гарах зардал, хил гаалийн үйлчилгээ гэсэн 3 дэд үзүүлэлтээр, Замын Үүд, Алтанбулаг, Буянт-Ухаа, бусад хилийн боомтын үнэлгээгээр гаргалаа.

Гадаад худалдаа эрхлэгчид хил, гаалийн үйл ажиллагааг **2.59-2.81** оноогоор **дундаж** түвшинд үнэлсэн байна.


Хил, гаалийн үйлчилгээний чанарын үзүүлэлтээр Буянт-Ухаа гаалийн газрын үйлчилгээг **2.76** оноогоор дундаж түвшинд үнэлж, бусад боомтын үйлчилгээг **хангалтгүй (2.59-2.63)** гэж дүгнэсэн байна. Хил, гааль дээр зарцуулах зардлын хувьд гаалийн газар, хилийн боомтуудын хооронд төдийлөн ялгаа байхгүй бөгөөд зарцуулах зардлын хэмжээг **дундаж (2.63-2.69)** гэж хариулжээ.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүд Алтанбулагийн хил дээр хугацаа **их** зарцуулдаг (**2.61**) бол Буянт-Ухаа гаалийн газар **дундаж (2.82)** буюу харьцангуй шуурхай үйлчилдэг гэсэн байна.

<sup>7</sup> Үнэлгээний тайлбар: Багана дахь үнэлгээний утга 1-маш хүндрэлтэй, 2-хүндрэлтэй, 3-дунд зэрэг, 4-хүндрэл бага, 5-хүндрэлгүй.



Зураг 6. Хил, гаалийн үйлчилгээ, зардал, зарцуулах хугацааны үнэлгээ



Эх сурвалж: Монголын бизнесийн орчны судалгаа 2020


Хил, гаалийн үйлчилгээний үзүүлэлтийг 2017 оны бизнесийн орчны судалгааны үр дүнтэй харьцуулбал өмнөх судалгаагаар Замын Үүд, Алтанбулаг, Буянт Ухаагийн хил, гаалд зарцуулдаг хугацаа ба зардал *маш их, их* гэж 50-52% нь үнэлж байсан бол эдгээр үзүүлэлт *34-38%* болж *буурсан* байна. Энэ нь хил, гаалийн үйлчилгээ харьцангуй *сайжирч* байгааг илтгэж байна.

## 2.6. Гадаад улсын зохицуулалт, хил гаалийн үйлчилгээ

Гадаад худалдаа эрхлэхэд дотоодын бизнесийн орчноос гадна худалдааны түнш орнуудын импортын тариф, тарифын бус зохицуулалт, транзит тээврийн зардал, хөрш орнуудын гаалийн үйлчилгээ, хил дээрх зарцуулах хугацаа тодорхой нөлөө үзүүлдэг. Иймд гадаадын улс орны зохицуулалт, хил гаалийн үйлчилгээний нөхцөл байдлын талаар тодрууллаа.

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүд гадаад худалдааны түнш орнуудын импортын *тариф өндөр (50.8%)*, *тарифын бус зохицуулалт ихтэй (48.3%)*, транзит тээврийн *зардал их (52.8%)*, ОХУ-ын хил дээр зарцуулах *хугацаа урт (53.4%)*, БНХАУ-ын хил дээр зарцуулах *хугацаа урт (40.7%)* байгаа нь гадаад худалдаа эрхлэхэд хүндрэл учруулж байна гэж хариулсан байна. Ялангуяа ОХУ-ын хил дээр зарцуулах хугацаа урт (*2.34*), транзит тээврийн зардал өндөр (*2.39*) байгаа нь гадаад худалдаа эрхлэгчдэд хамгийн их хүндрэл учруулж байна.

Зураг 7. Гадаад худалдаанд худалдааны түнш орнуудын зохицуулалт, хил гаалийн үйлчилгээний үзүүлэх нөлөөллийн үнэлгээ<sup>8</sup>



Эх сурвалж: Монголын бизнесийн орчны судалгаа 2020

Хэдийгээр гадаад улс орны гадаад худалдааны бодлого, зохицуулалт, үйл ажиллагаанд шууд нөлөөлөх, өөрчлөх боломжгүй ч Засгийн газар хоорондын хэлэлцээр хийх, хамтран ажиллах замаар, мөн гадаад худалдаа эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх замаар тэдэнд тулгарч буй эдгээр саад бэрхшээлийн нөлөөллийг тодорхой түвшинд бууруулах боломжтой юм.

## 2.7. Гадаад худалдаа эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл


Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс гадаад худалдаа эрхлэхэд хамгийн их хүндрэл, бэрхшээл учруулдаг хүчин зүйлсийг тодруулахад валютын ханшийн хэлбэлзэл (маш хүндрэлтэй 37%, хүндрэлтэй 35%) хамгийн их хүндрэл учруулдаг гэж хариулсан байна.

Түүнчлэн гадаад худалдааны санхүүжилт авах боломж муу (маш хүндрэлтэй 24%, хүндрэлтэй 38%), гадаад зах зээл дэх өрсөлдөөн ширүүн (маш хүндрэлтэй 23%, хүндрэлтэй 34%) байдаг нь бэрхшээл үүсгэдэг гэжээ. Мөн гадаад зах зээлд гарахад нь зуучлах, бизнесийн хамтрагчтай

<sup>8</sup> Үнэлгээний тайлбар: Багана дахь үнэлгээний утга 1-маш их, 2-их, 3-дунд, 4-бага, 5-маш бага; 'гадаад орны тарифын бус зохицуулалт' үзүүлэлтийн хувьд 1-маш хүндрэлтэй, 2-хүндрэлтэй, 3-дунд зэрэг, 4-хүндрэл бага, 5-хүндрэлгүй.

холбож өгөх үйлчилгээ дутмаг, гадаад худалдаагаар мэргэжсэн хүний нөөцийн олдоц муу, гадаад худалдаа эрхлэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл хомс, гадаад худалдааны гэрээ байгуулах чадвар хангалтгүй байгаа нь хүндрэл учруулж байна.

Зураг 8. Гадаад худалдаа эрхлэхэд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийн үнэлгээ<sup>9</sup>



Эх сурвалж: Монголын бизнесийн орчны судалгаа 2020

Гадаад худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үнэлгээг салбараар нь харьцуулбал Барилгын салбарынхан гадаад худалдаа эрхлэхэд хамгийн төвөгтэй гэж хариулсан байна. Тухайн салбарт гадаад худалдаа эрхлэхэд валютын ханшийн хэлбэлзэл (2.45), мэргэжлийн ур чадвар бүхий хүний нөөцийн олдоц (2.54), бизнесийн түнш, хамтрагч олох суваг (1.93), гадаад зах зээлийн талаарх мэдээллийн олдоц (2.14) *ихээхэн хүндрэл* үүсгэдэг гэж хариулсан байна.

<sup>9</sup> Үнэлгээний тайлбар: Багана дахь үнэлгээний утга 1-маш хүндрэлтэй, 2-хүндрэлтэй, 3-дунд зэрэг, 4-хүндрэл бага, 5-хүндрэлгүй

Монгол улсын экспортын голлох хувийг бүрдүүлдэг Уул уурхайн салбарын ААН-үүд гадаадын түнш, харилцагчтай гэрээ, хэлцэл байгуулах чадвар гадаад худалдаа эрхлэхэд *маш их хүндрэл* үүсгэдэг (1.60) гэж хариулсан нь анхаарал татаж байна. Урт хугацаанд үргэлжлэх, их хэмжээний үнийн дүнтэй гадаад худалдааны гэрээ байгуулах шаардлага үүсдэг нь уул уурхайн салбарын онцлог юм. Нөгөө талаар гадаад зах зээлд худалдаалж буй бүтээгдэхүүний онцлогоос хамааран байнгын харилцагч, худалдан авагчтай байдаг тул тус салбарынхан гадаад зах зээлийн өрсөлдөөний нөлөөг бусад салбартай харьцуулахад харьцангуй бага буюу *дундаж* (2.79) түвшинд үнэлсэн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдаа эрхлэхэд тулгарч буй бэрхшээлийн үнэлгээ, салбараар<sup>10</sup>

Салбар	Валютын ханш	Гадаад худ-ны санхүүжилт	Гадаад ЗЗ-ийн өрсөлдөөн	Хүний нооцийн олоц	Хамтрагч олох	Гэрээ байгуулах чадвар	Мэдээллийн олоц
Худалдаа	2.60	2.66	2.61	2.67	2.27	2.02	2.35
Үйлчилгээ	2.66	2.69	2.57	2.70	2.35	2.07	2.37
Боловсруулах үйлдвэр	2.55	<b>2.61</b>	2.56	2.60	2.23	2.08	2.28
Уул уурхай	3.02	2.96	<b>2.79</b>	3.00	2.27	<b>1.60</b>	<b>2.52</b>
Барилга	<b>2.45</b>	2.68	2.57	<b>2.54</b>	<b>1.93</b>	1.67	<b>2.14</b>
Тээвэр	2.79	2.67	2.58	2.67	<b>2.50</b>	1.96	2.33
Мал аж ахуй	2.58	2.68	2.74	2.74	2.42	2.16	2.37
Газар тариалан	2.70	2.87	2.63	2.62	2.33	<b>2.10</b>	2.43
Мэдээллийн технологи	2.55	2.66	<b>2.50</b>	2.59	2.24	1.79	2.37
Аялал жуулчлал	<b>2.80</b>	<b>3.10</b>	2.55	<b>3.05</b>	2.30	1.62	2.29

Эх сурвалж: Монголын бизнесийн орчны судалгаа 2020

## 2.8. Эдийн засгийн хэлэлцээрүүдийн үр дүн

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газар худалдааны түнш улс орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Үүний илэрхийлэл нь Монгол улс, Япон улс хоорондын ЭЗТХ-ээр байгуулсан бол манай улс Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий системд хамрагдаж, татварын хөнгөлөлт элдэх боломж бүрдээд олон жил өнгөрчээ.

<sup>10</sup> Үнэлгээний утга: 1-маш хүндрэлтэй, 2-хүндрэлтэй, 3-дунд зэрэг, 4-хүндрэл бага, 5-хүндрэлгүй.

Эдгээр хэлэлцээрийн үр дүн, хөнгөлөлт, чөлөөлөлтийн боломжийг аж ахуйн нэгжүүд ашиглаж чадаж буй эсэхийг тодруулахад судалгаанд хамрагдсан компаниудын 9.8% буюу **109 ААН** Япон улсад бүтээгдэхүүн экспортолж, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн дагуу татварын хөнгөлөлт эдэлсэн гэж хариулсан бол Япон улсаас бараа, бүтээгдэхүүн импортлохдоо татварын хөнгөлөлт эдэлсэн гэж **95 ААН**, Япон улстай тогтоосон хамтын ажиллагаа өргөжсөн гэж **144 ААН** хариулсан байна.

Мөн Европын Холбооноос тодорхой шаардлага хангасан хөгжиж буй орнуудад олгодог Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн дагуу бүтээгдэхүүнээ экспортолж, хөнгөлөлт эдэлдэг гэж судалгаанд хамрагдсан **101** аж ахуйн нэгж хариулжээ.

Монгол-Японы ЭЗТХ, Европын Холбооны ХЕС-д хамрагдаж, татварын хөнгөлөлт эдэлсэн ААН-үүд нь судалгаанд хамрагдсан гадаад худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн **8-13%**ийг бүрдүүлж байгаа нь нэн хангалтгүй үзүүлэлт юм. Хөнгөлөлтийн боломж, хэлэлцээрүүдийн үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, гарал үүслийн шаардлагыг хангах, түүнчлэн хэлэлцээрт хамрагдан хөнгөлөлт эдлэх боломжийн талаар мэдээлэл, судалгааг өргөжүүлэх шаардлагатай болох нь эндээс харагдаж байна.

### 3. ДҮГНЭЛТ

Гадаад худалдаа эрхэлдэг 1111 аж ахуйн нэгжийг хамруулсан судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

- Гадаад худалдаа эрхлэгчид экспорт хийхтэй холбоотой нөхцөл байдлыг **2.36** оноогоор, импорт хийхтэй холбоотой нөхцөл байдлыг **2.67** оноогоор **хүндрэлтэй** хэмээн үнэлсэн нь гадаад худалдаа эрхлэхэд олон талын хүндрэл, бэрхшээл тулгарч байгааг илтгэж байна.
- Гадаад худалдааны чиглэлээр ажиллаж буй ААН-үүд экспортыг дэмжихэд чиглэсэн төрийн, олон улсын, төрийн бус байгууллагуудын дэмжлэгийг **муу** гэж дүгнэсэн бөгөөд ялангуяа төрийн байгууллагуудын дэмжлэгийг хамгийн бага, түүгээр зогсохгүй гадаад худалдаа эрхлэхэд саад учруулдаг гэжээ. Гадаад худалдаа эрхлэгчид экспорт, импортын зөвшөөрөл авахад зарцуулах хугацаа их, зөвшөөрөл авахын тулд бүрдүүлэх бичиг баримтын тоо олон, зөвшөөрөл авахад гарах зардал, төлбөр хураамжийн хэмжээ өндөр гэж хариулсан тул зөвшөөрөл олгох үйл явцыг хялбарчлах, цахимжуулах шаардлагатай байна.
- Гадаад худалдааны санхүүжилт, бизнесийн зөвлөгөө, гадаад төлбөр тооцоо, гадаад худалдааны даатгалын үйлчилгээний чанар, хүртээмж

хангалтгүй байгаа нь гадаад худалдаа эрхлэхэд саад тотгор болж байна. Үүний зэрэгцээ гадаад зах зээлтэй холбоо тогтоох, гадаад зах зээлийн талаар мэдээлэл цуглуулах, гэрээ хэлцэл байгуулах зэрэг гадаад худалдаа эрхлэгч ААН-үүдийн дотоод чадавх сул байгаа нь гадаад худалдаа эрхлэхэд сөргөөр нөлөөлж байна.

- Түүнчлэн валютын ханшийн хэлбэлзлийн нөлөө **маш их хүндрэл** үүсгэж байгааг онцгойлон анхаарах шаардлагатай байна.
- Экспорт, импорт хийхэд дотоодын тээврийн зардал **өндөр**, тээвэрлэлтэд зарцуулах хугацаа **их**, тээврийн олдоц, хүрэлцээ **хангалтгүй** байгаа нь сөрөг нөлөө үзүүлж байна.
- Гадаад худалдаа эрхлэхэд дээр дурдсан дотоод хүчин зүйлсээс гадна худалдааны түнш орнуудын импортын *татвар, тарифын бус зохицуулалт*, транзит тээврийн *зардал*, ОХУ-ын хил дээр зарцуулах *хугацаа* хүндрэл учруулж байна. Хэдийгээр гадаад улс орнуудын гадаад худалдааны бодлого, зохицуулалтад шууд нөлөөлөх, өөрчлөх боломжгүй ч Засгийн газар хоорондын хэлэлцээр хийх, хамтран ажиллах замаар, мөн гадаад худалдаа эрхлэгчдэд тал бүрийн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх замаар тэдэнд тулгарч буй саад бэрхшээлийн нөлөөллийг бууруулах боломжтой юм.
- Судалгаанд оролцогчид гадаад худалдаа эрхлэхтэй холбоотой үзүүлэлтүүдээс тээвэр зуучийн үйлчилгээг хамгийн өндөр оноогоор (2.88) буюу **дундаж** түвшинд хүрсэн гэж үнэлсэн байна.

Гадаад худалдаа эрхлэхэд тааламжтай орчин, нөхцөлийг бүрдүүлэхийн тулд зөвхөн төрийн байгууллагын дэмжлэгт найдах бус гадаад худалдаанд оролцогч бүхий л талууд, тухайлбал төрийн, бизнесийн, олон улсын болон төрийн бус байгууллагууд харилцан уялдаатай, зорилго төлөвлөгөөтэй хамтран ажиллах шаардлагатай байна.

### **Ашигласан материал**

- Ayisha M, Thowseaf S. 2016. Factors Influencing Export – A conceptual analysis.
- Calantone R. J, Daekwan Kim, Schmidt J. B, and Cavusgil S. T. 2005. The influence of internal and external firm factors on international product adaptation strategy and export performance: A three-country comparison. Journal of Business Research.
- Craig Julian. 2004. The key factors influencing the export marketing performance of Thai export firms.

- Institute for Competitiveness and National Institution for Transforming India. 2020. Export preparedness index 2020.
- Hoyland B, Moene K, and Willumsen F. 2008. Be careful when Doing Business.
- Marco Fugazza. 2004. Export Performance and Its Determinants: Supply and Demand constraints.
- Musibau Adetunji Babatunde. 2012. Determinants of export performance in developing countries: A Survey of the evidence.
- Simon Commander and Jan Svejnar. 2009. Business environment, exports, ownership, and firm performance.
- Tibor Besedes and Juan Blyde. 2010. What Drives Export Survival? An analysis of export duration in Latin America.
- Yong Yang and Sushanta Mallick. 2013. Explaining cross-country differences in exporting performance: The role of country-level macroeconomic environment. *International Business Review*.
- World Bank group. 2019. Doing business report 2003-2019.
- МУИС Бизнесийн сургууль, МҮХАҮТ. 2020. Монголын бизнесийн орчны судалгаа 2020.
- МУИС Бизнесийн сургууль, МҮХАҮТ. 2017. Монголын бизнесийн орчны судалгаа 2017.
- Монгол Улсын Статистикийн мэдээллийн нэгдсэн сан